

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛ, ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

Д.Сувдаа*, Т.Мөнхзаяа**

Хураангуй: Татварын тогтолцооны дотоод логик, агуулгаас үүдээд дэлхийн аль ч улс оронд хүн амаас авах татварыг хэрэгжүүлэх, хянахад хамгийн төвөгтэй төрөлд багтдаг. Манай орны хувьд шилжилтийн эдийн засаг, шинэчлэлийн бодлогын тодорхой онцлог, нөхцөлтэй холбоотой олон хязгаарлалт үүсэж байсан боловч татварын тогтолцоонд энэхүү татварын гүйцэтгэх үүрэг, байр суурь байнга нэмэгдэж ирсэн нь түүний судалгаа, бодлого зохицуулалтын асуудлыг шинэ өнцгөөс харж боловсруулахыг шаардаж байна. Бид энэхүү өгүүлэлээрээ гадны судлаачдын хийсэн хувь хүний орлогын албан татвар /цаашид ХХОАТ гэж товчлох/ ногдуулах зарчмын талаарх онол-арга зүйн судалгаа болон хөгжингүй болон хөгжиж буй орнуудын ХХОАТ-ын бодлогод гарч буй шинэчлэлийг харьцуулан дүгнэж, энэхүү татварыг тэгш шударга байх зарчмын дагуу зүй зохистой ногдуулахтай холбоотойгоор өөрийн оронд тулгарч буй ХХОАТ ногдуулах суурийг хэрхэн бодитой тооцох тухай судалж орлогын тэгш бус байдлыг зохицуулахад татварын өсөн нэмэгдэх хувь хэмжээг хэрэглэх нь зохистой гэсэн дүгнэлтэнд хүрсэн болно. ХХОАТ нь хүн амын ахуй амьдрал, ажил үйлстэй хамгийн нягт холбоотой байдаг тул иргэдийн орлого, хуримтлал, хэрэглээ, хөдөлмөр эрхлэлт, хүн амзүйн гээд тулгамдсан олон асуудлыг шийдвэрлэхэд төрийн зүгээс идэвхитэй оролцож зохицуулах чухал суваг болж байдгийг улам гүнзгий судалж боловсруулах шаардлагатай байна.

Түлхүүр үг: хувь хүний орлогын албан татвар

Онолын хэсэг

ХХОАТ-ын нийгэм эдийн засагт гүйцэтгэх үүрэг, зорилт, зарчим, нөлөөллийн талаар A.Smith (1776), D.Ricardo (1817), I.Overstone (1853),

* МУИС-ийн Бизнесийн сургууль, (Email) suvdaakorea@gmail.com

** МУИС-ийн Бизнесийн сургууль, (Email) munkhmunkh@gmail.com

C.Stuart (1889), Edgeworth (1897) нарын ХҮИИ, ХІХ зууны сэтгэгчид судалж, татвар ногдуулалтын тэгш шударга, үр ашигтай, төлж болохуйц, энгийн ойлгомжтой байх үндсэн зарчмуудын үндэслэлийг бий болгосон байдаг. Мөн тухайн үед татварыг хувь хувь хүний орлого, хөрөнгө, хэрэглээний алинд нь ногдуулах, төлөх татварын хэмжээг юунд үндэслэж хэрхэн тогтоох талаар маргаан үүсч татварыг үр өгөөжийн зарчмаар ногдуулах тухайлбал, төлсөн татварын хэмжээ эргээд нийтийн сан хөмрөг/төсвөөс хүртэх өгөөж хоорондоо шууд уялдаатай байх нь зүйтэй гэж үзэж байсан (J.S.Mill) бол татварыг төлбөрийн чадварынхаа хэрээр төлөх нь илүү шударга (A.Smith) гэсэн үзэл баримтлалыг гаргаж тавьсан байна.³ Татварын бодлого нь татварын бүтэц, загвартай холбоотой маш олон тооны шийдвэр гаргах урлаг юм. Эдгээр шийдвэрүүд нь татварын *үр ашигтай, тэгш шударга, удирдаж болохуйц* байх гэсэн 3 үндсэн шалгуур зарчмаар үнэлэгддэг (Аvi Yonah, 2006).

Бид энэхүү өгүүлэлдээ олон улсын хэмжээнд болон Монгол улсын ХХОАТ-ын бодлого, шинэчлэлийг дараах байдлаар харьцуулан судаллаа. Үүнд:

- Хөгжингүй орнууд (ЭЗХАХБ-ын гишүүн орнуудаар- 34)
- Хөгжиж буй орнууд (Emerging markets and Transition countries-20)
- Монгол улсын ХХОАТ-ын бодлого, зохицуулалт

Хүснэгт 1. ХХОАТ-ын хувь хэмжээ (бус нутгаар)⁴

Татварын хувь	Европ	Ази	Өмнөд Америк	Африк	Хойд Америк
0 буюу татваргүй	-	Бахрейн, Кувейт, Оман, Катар, Арабын Нэгдсэн Эмират Улс	Бахам, Кайман арлууд	-	Бермуд
1-10%	Болгар	Казахстан	-	-	-
11-20 %	Чех, Унгар, Румын, Орос, Серби, Словак, Украин	Афганистан, Армэн, Гүрж, ХонКонг, Иордан, Макао, Сингапур	Коста Рика	Ангол, Египт, Маврити, Судан	-
21-30 %	Латви	Бангладеш, Кипр, Энэтхэг, Индонез, Малайз	Бразил, Гондурас, Ямайк, Мексик, Панам, Перу, Уругвай	Ботсвана, Малай, Танзани	-
31-40 %	Хорват, Гибралтар, Мальт, Польш, Швейцарь	БНСУ, Филиппин, Тайван, Тайланд, Турк, Вьетнам	Аргентин, Колумб, Эквадор, Гватемал, Венесуэль	Мозамбик, Өмнөд Африк, Тунис, Зимбабе	АНУ
41-50 %	Австри, Бельги, Финланд, Франц, Герман, Грек, Исланд, Ирланд, Итали, Люксембург, Португаль, Норвеги, Испани, Англи	Хятад, Израиль, Япон	Netherlands Antilles	-	Канад
51%+	Дани, Нидерланд, Швед	-	Аруба	-	-
Дундаж хувь	35	23	28	27	27

Эх сурвалж: KPMG. (2011). Individual Income tax and Social Security Rate Survey

Татварын бодлогын шинэчлэлийн чиглэл: Flat Tax (Тэгш хувьтай татвар)

3 (Сувдаа, 2016)

4 (KPMG, 2011)

шинээр сүүлийн жилүүдэд татварын хөгжилд гарч байгаа хүчтэй өөрчлөлтийн нэг нь “Тэгш хувьтай татвар” бөгөөд нилээд олон оронд хэрэгжүүлэх “дон”, “моод” бий болоод байна. Энэ нь нилээд язгуур шинэчлэлийн тухай асуудал яригдаж байгаа хэдий ч шинжилгээ судалгаа, үндэслэлээсээ илүүтэй “мэдэгдэл”, “хоосон үг” төдий байдал ч мөн ажиглагдаж байна.

Хүснэгт 2. Тэгш хувьтай татварыг нэвтэрүүлсэн байдал⁵

№	Улсын нэр	Батлагдсан он	ХХОАТ-ын хувь		Компаний орлогын татвар/ Шинэчлэлийн дараа	Суурь хөнгөлөлтийн өөрчлөлт
			Дараа	Өмнө		
1	Эстон	1994	26	16-33	26	Хязгаартай өсөлт
2	Литва	1994	33	18-33	29	Нилээд их өсөлт
3	Латви	1997	25	25 ба 10	25	Бага зэрэг бууралт
4	ОХУ	2001	13	12-30	37	Хязгаартай өсөлт
5	Украйн	2004	13	10-40	25	Өсөлт
6	Словак	2004	19	10-38	19	Нилээд их өсөлт
7	Гүрж	2005	12	12-20	20	Багасгасан
8	Румын	2005	16	18-40	16	Өссөн
9	Монгол	2006	10	10-30	10 ба 25	Өөрчлөгдөөгүй

Эх сурвалж: Michael Keen, Yitae Kim, & Ricardo Vazzano, 2006, "Flat Tax: Principles and Evidence", IMF Working Paper WP 06/218, pp6

ХХОАТ ногдуулах суурь нь “орлого” -ын хандлага давамгайлж байна. Мөн өсөн нэмэгдэх хувь хэмжээ хэрэглэх хандлага давамгайлж байна. Орлогын татварын цаашдын шинэчлэл нь Dual/хосолсон болон flat/тэгш хувьтай татвараас сонголт хийх төлөвтэй байна.

Дэлхий дахинд гарсан татварын өөрчлөлт (2015 он)⁶

- Богино хугацаанд, эдийн засгийн уналтын үр дагаврыг давж гарах, эдийн засгаа сэргээж тэнцвэржүүлэхэд чиглэсэн өсч буй орлогын хэрэгцээг хангахад чиглэсэн бодлого барьж байна.
- Сүүлийн 10-15 жилд татварын хувь хэмжээ маш бага хэмжээгээр өөрчлөгдсөн. Жи: Корпорацийн ашгийн татвар 2014 онд-23.64% байсан бол 2015 онд 23.68% болсон. (өөрчлөлт- 0.04%)
- ХХОАТ-ын хувьд хэрэглэгчдийн худалдан авах чадварыг хадгалахын тул татварын хөнгөлөлтийн шинэ хэлбэрүүдийг хэрэглэх, татварын босгыг бууруулах зэрэг арга хэмжээ авсан.
- ХХОАТ-ын хэмжээ 0.41%-иар өсч, дунджаар 31.53% байна.

Хөгжиж буй орнуудын татварын шинэчлэлд тулгарч буй нийтлэг

5 (Michael, Yitae, & Ricardo, 2006)

6 (KPMG, 2015)

бэрхшээлцүд⁷


- Татвар ногдуулалтад хүндрэл үүсч байна. Захиргааны чадавхи сул, татвар төлөх сэтгэлгээ төлөвшөөгүй. Албан бус секторын ДНБ-д эзлэх хувь дунджаар 40%, зарим оронд 60% эзэлж байна.(Schneider, Buehn, and Montenegro (2010).
- Татварын орлогын удирдлага сул, татвар төлөгчдийн ёс суртахуун доогуур, засаглал сул (Attila, Chambas, and Combes, 2008).
- Засаглалын бусад үзүүлэлтүүд сул (хуулийн хэрэгжилт сул; улс төрийн тогтворгүй байдал)
- Татварын системийг үгүйсгэх хандлага:Үндэстэн дамнасан корпорацн, төрийн өмчит үйлдвэрийн газруудын татварын орлого төлөвлөх, орлого цуглуулахад төвөгтэй.
- Санхүүгийн институциуд татвартай холбоотой үнэ цэнэтэй мэдээллүүдийг өнгөц ашигладаг.
- Олон улсын татварын өрсөлдөөнийг эрчимжүүлснээс, мөн бүс нутгийн интеграцчилалтай холбоотой. Худалдааг либеральчилснаас орох орлогын дарамт/шахалт;
- Олон улсын үйлчилгээнд татвар ногдуулах, хянахад хүндрэлтэй г.м бэрхшээлүүд тулгарч байна.

Судалгааны хэсэг:

Монгол улс зах зээлийн харилцаанд шилжсэн эхний жилүүдэд ХХОАТ-ын татварын нийт орлогод эзлэх хувь харьцангуй бага дөнгөж 2.3 хувийг эзэлж байсан бол сүүлийн 20 гаруй жилийн дундажаар 6.3%, 2015 оны урьдчилсан гүйцэтгэлээр 9.9% болтол нэмэгдэж ялангуяа 2006 олноос эхлэн орон нутгийн төсвийн орлогын үндсэн эх үүсвэр болж өсөх хандлагатай байна.

7 (IMF, 2011)

Зураг 1. Монгол улсын татварын орлогын бүтэц, хувиар



Эх сурвалж: Сангийн яамны статистикт үндэслэсэн судлаачийн тооцоолол

Хувь хүний төлж буй орлогын татварын бүтцийг татвар ногдуулж буй арга, орлогын эх үүсвэрийн төрлөөр авч үзэхэд хэдийгээр олон төрлийн эх үүсвэрт тухайлбал хувиараа бизнес эрхлэгч иргэдийн ажил үйлчилгээний төрлөөс хамааран патент, жишиг татвар ногдуулж; цалин хөдөлмөрийн хөлсний орлого, аж ахуй эрхэлсний орлого, хөрөнгийн болон хөрөнгө борлуулсны орлого гэх зэрэг бүх эх үүсвэрүүдэд тусгай хувиар татвар ногдуулж байгаа боловч тогтмол цалингийн орлогоос бусад орлогын эх үүсвэрийг татварт хамруулж, татвар ногдуулж, хурааж чадахгүй байна гэж үзэж байна.


Хүснэгт 3 ХХОАТ-ын орлогын бүтэц

Үзүүлэлт	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014
Жиншгээр ногдуулсан татвар	1.39	1.08	1.03	1.2	1.03	1.3	1	1.06	0.91	0.63	0.5	0.4	0.3
Малчин, мал бүхий иргэдийн	6.52	5.85	4.17	4.08	3.4	3.82	3.03	1.62	0.12	0.03	0	0	0
Патент	3.81	3.86	2.76	2.5	2.07	2.59	1.7	1.67	1.46	1.28	0.9	0.8	0.7
Цалин, түүнтэй адилтгах орлогоос төлсөн татвар	85.4	86.2	89.5	90.5	90.9	87.7	91.5	93.2	94.6	95.2	95.3	96.1	93.0
Аж ахуй эрхэлсний орлого	2.85	2.97	2.51	1.65	2.58	4.53	2.76	2.42	2.85	2.85	3.4	2.7	6.0
Нийт дүн	100	100	100	100	100	100	100	100	100	100	100.0	100.0	100.0

Сүүлийн 22 жилийн дунджаар хотын өрхийн орлогын 52.2% нь цалин хөдөлмөрийн хөлсний орлого байхад хөдөөгийн өрхийн 22.4% нь цалингийн орлого байгаа нь хөдөөд ажлын байр хомс, гол төлөв ХАА үйлдвэрлэл зонхилдогос бусад орлогын эх үүсвэр бага ихэвчлэн тэтгэвэр тэтгэмж,

зээлийн эх үүсвэрээр амьдарч байна.⁸

Зураг 2. Өрхийн сарын дундаж орлогын бүтэц, хувиар
(Хот, хөдөөд) (1992-2014 он)



Эх сурвалж: ҮСХ (2004). “Монгол улс зах зээлд” статистикийн эмхтгэл 1989-2002, Статистикийн эмхтгэл 2003-2014

Монгол улсын ХХОАТ-ын бодлого боловсруулах, шинэчлэл хийхэд дараах хүчин зүйлсийг харгалзан үзэх нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

1. Өрхийн орлого болон хэрэглээний түвшин
2. Ажил эрхэлж буй нэг хүнд ногдох гэжээлгэгчийн тоо
3. Өрхийн мөнгөн орлогод хадгаламж, хуримтлалын эзлэх хувь
4. Цалингийн түвшин
5. Татвараас чөлөөлөгдөх суурь орлогын хэмжээ зэрэг болно.

Учир нь ХХОАТ ногдуулах суурийг тодорхойлохдоо татвар төлөх чадварыг голлон анхаардаг зарчим дэлхийн улс орнуудад нийтлэг хэрэглэгдэж байна.

Дээрх үзүүлэлтүүд Монгол улсад ямар түвшинд байгаа болон татвар ногдуулалтад хэрхэн харгалзаж байгаа талаар тус бүрээр нь авч үзье.


1. Өрхийн орлого болон хэрэглээний түвшин:

Монгол улсын хувьд ХХОАТ төлөгч нь хувь хүн байхаар хуульчилсан.

⁸ (ҮСХ, 1989-2014)

Гэхдээ хувь хүний татвар төлөх чадварыг онолын хувьд зөвхөн орлогод үндэслэн тодорхойлох нь оновчгүй гэж үздэг. Хэйг-Симонсын (Haig&Simons) орлогын тодорхойлолт ёсоор татвар төлөх чадвар нь тухайн хугацааны хэрэглээний нийлбэр дээр цэвэр хөрөнгийн өсөлтийг нэмж тооцно гэж үздэг⁹. Өөрөөр хэлбэл татвар төлөгчийн орлогоос гадна хэрэглээ болон цэвэр хөрөнгийн өсөлтийг тооцох шаардлага тулгардаг. Иймээс манай орны хувьд татвар татвар төлөгч иргэдийн өрхийн орлогыг хэрэглээнийх нь түвшинд үндэслэн судалж үнэлэлт дүгнэлт өгөхийг зорьсон болно.

Зураг 3. Бодит мөнгөн орлого (мян.төг), өрхийн бүлэглэлтээр, 2010 оны зэрэгцүүлэх үнээр



Эх сурвалж: ӨНЭЗС-2015,УБСЕГ

2015 оны жилийн эцсийн байдлаар нийт өрхийн 57.7% буюу 495 мян.өрх сарын 500.0 мян.төг хүртэл орлоготой байгаа нь дээрх судалгаанаас харагдаж байна.¹⁰

2. Ажил эрхэлж буй нэг хүнд ногдох тэжээлгэгчийн тоог тодорхойлох нь:

Хувь хүний татвар төлөх чадварыг илүү бодитой тодорхойлохын тулд ажил эрхэлж буй нэг хүнд ногдох тэжээлгэгчийн тоог тодорхойлох хандлага хөгжингүй орнуудад нийтлэг хэрэглэгдэж байна. Монгол улсын хувьд энэ

9 (Simons, 1938)

10 (УБСЕГ, 2015)

үзүүлэлтийг тооцохын тулд дараах 3 хувилбараар тооцоолол хийв. Бидний тооцоолсноор 1 ажил эрхэлж буй хүнд 2.23- 3.94 тэжээлэгч ногдож байна гэсэн тооцоо гарч байна.

$$PPE^0 = \frac{\text{Суурин хүн амын тоо} - \text{Тэтгэвэр авагчдын тоо}}{\text{Ажиллагсадын тоо}} = \frac{2704.5 - 390.2}{1037.7} = 2.23$$

$$PPE_{max}^0 = \frac{\text{Суурин хүн амын тоо}}{\text{Ажиллагсадын тоо}} = \frac{2704.5}{1037.7} = 2.60$$

$$PPE^1 = \frac{\text{Суурин хүн амын тоо} - \text{Тэтгэвэр авагчдын тоо}}{\text{НДШ төлөгчийн тоо}} = \frac{2704.5 - 390.2}{686.4} = 3.37$$

$$PPE_{max}^1 = \frac{\text{Суурин хүн амын тоо}}{\text{НДШ төлөгчийн тоо}} = \frac{2704.5}{686.4} = 3.37$$

Энэ үзүүлэлт нь ХХОАТ тооцох суурь, татварын суурь хөнгөлөлт, шатлалын тоо болон хэмжээг оновчтой тогтоох үндэслэл болно гэж үзэж байна.

3. Өрхийн мөнгөн орлогод хадгаламж, хуримтлалын эзлэх хувь:

Олон улсын жишгээр хадгаламж болон хуримтлалын орлогод тусгай хувь хэмжээгээр татвар ногдуулж байна. Өөрөөр хэлбэл ХХОАТ-ын үндсэн хувийг хэрэглэхээс илүүтэйгээр иргэдийн дотоод хуримтлалыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор тусгай, бага хувь хэрэглэх хандлага давамгайлж байна.

Монгол улсын хувьд иргэд орлогынхоо хэдэн хувийг хадгаламжид хийж буй болон хуримтлалын хэмжээ хэр зэрэг байгааг бид тодорхойлохдоо ӨНЭЗС-ны хэрэглээ болон мөнгөн орлогод хадгаламжийн эзлэх хувь гэсэн судалгааг үндэслэсэн татвар ногдуулах суурийг тооцоолоход ашигласан болно.

Хүснэгт 4. Өрхийн мөнгөн орлогод хадгаламжийн эзлэх хувь¹¹

	2007-2008 он	2012 онд						
	Хадгаламжтай өрхийн эзлэх хувь	Хадгаламжтай өрхийн эзлэх хувь	Өрхийн сарын дундаж нийт орлого	Өрхийн сарын дундаж мөнгөн орлого	Сүүлийн 12 сард хадгаламжид хийсэн мөнгөний дундаж хэмжээ	Сүүлийн 1 сард хадгаламжид хийсэн мөнгөний дундаж хэмжээ /нийт өрхөд тархалтаар/	Хадгаламжид хийсэн мөнгөний нийт орлогод эзлэх хувь	Хадгаламжид хийсэн мөнгөний мөнгөн орлогод эзлэх хувь
I	0.7	0.6	293,016	240,552	525,434	2,677	0.9	1.1
II	1.2	1.0	413,816	354,190	952,408	8,229	2.0	2.3
III	1.4	1.3	507,623	436,536	538,675	5,969	1.2	1.4
IV	1.7	1.6	608,753	530,848	790,206	10,372	1.7	2.0
V	1.9	1.8	678,362	602,587	714,867	10,994	1.6	1.8
VI	2.5	2.1	777,175	692,776	915,611	16,391	2.1	2.4
VII	2.7	2.5	888,654	800,050	963,961	19,772	2.2	2.5
VIII	3.3	2.6	976,334	896,573	1,400,359	30,674	3.1	3.4
IX	3.8	3.2	1,201,299	1,115,308	1,849,104	49,014	4.1	4.4
X	4.5	4.5	1,855,521	1,750,395	3,014,575	113,627	6.1	6.5
Бүгд	23.6	21.3	819,990	741,918	1,505,286	26,768	3.3	3.6


Эх сурвалж: ҮСХ, ӨНЭЭС 2007-2008, ӨНЭЭС 2012/урьдчилсан гүйцэтгэл/

Хүснэгтээс үзэхэд Монгол улсын хамгийн орлого өндөртэй өрх нийт сарын мөнгөн орлогынхоо 6.5 хувийг хадгаламж хэлбэрээр хуримтуулж байхад, хамгийн бага орлоготой өрх 1.1 хувийг хадгалдаг гэсэн тооцоо гарч байна. Гэхдээ хадгаламжтай иргэн, өрхөд татвар ногдуулахдаа орлогын хэмжээ, хадгалуулж буй хугацаа, дансны тоо зэргийг харгалзан өсөн нэмэгдэх хувийг хэрэглэх нь зүйтэй гэж үзэж байна.

4. Цалингийн түвшин:

Монгол улсад цалин хөдөлмөрийн хөлсний орлого нь ХХОАТ ногдуулах үндсэн суурь орлого хэвээр байна. Өөрөөр хэлбэл ХХОАТ-ын 90 гаруй хувь нь зөвхөн цалин хөдөлмөрийн хөлсний орлогоос бүрдэж байна.

Зураг 4. Цалингийн бүтэц, мян төг (шатлалаар)



Эх сурвалж: УНДЕГ, 2016 оны урьдчилсан гүйцэтгэл

11 (ҮСХ, 2007-2008)

2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр нийгмийн даатгалын шимтгэл төлөгч иргэдийн 15.5% нь сарын 300.0 мян төгрөгөөс бага, 54.5% нь 300.0-900.0 мян төгрөгийн, 19.7% нь 1100.0-3000.0 мян.төгрөгийн цалингийн орлоготой иргэд байгаа нь бодит цалингийн хэмжээ доогуур байгааг илтгэж байна. Нөгөө талаас өсөн нэмэгдэх хувь хэрэглэх замаар орлогын ялгаатай байдлыг зөөлрүүлэх бодлого хэрэгжүүлэх шаардлагатай болохыг харуулж байна.

Дүгнэлт

Өнөөгийн байдлаар ХХОАТ-ын орлогын дийлэнх буюу 90 гаруй хувь нь зөвхөн цалин, хөдөлмөрийн хөлсний орлогоос бүрдэж байна. Энэ нь цалингаас бусад төрлийн орлого, эх үүсвэрээс татвар авч чаддаггүй, жижиг хувиараа бизнес эрхлэгчдийн төлж буй татварын хэмжээ маш бага, орлого болон төлбөрийн чадвараас үл хамааран тогтмол хэмжээний татвар тогтоосон, иргэдийн татварын талаарх боловсрол муу, татвар төлөх сэтгэлгээ төлөвшөөгүй, татвар төлснөөр буцаад төрөөс хүртэх үйлчилгээ, өгөөж мэдрэгддэггүй, татвар төлөгч болон нийт иргэдээ бүртгэх, тэдний үйл ажиллагаа орлогыг бүртгэх, хянах тогтолцоо сул, төрийн албадын үйл ажиллагаа нэгдмэл биш, мэдээлэл солилцох, хяналтын механизм сул зэрэг олон хүчин зүйлс нөлөөлж байгааг ХХОАТ-ын орлогын эх үүсвэрийн бүтэц нотолж байна.

ХХОАТ ногдуулалтыг боловсронгуй болгох асуудал нь татвар ногдох орлого, татварын хувийг тодорхойлоход оршино.Энэ нь чухамхүү татварын тэгш шударга байдлыг хангах, орлогын тэгш бус байдлыг зохицуулах бодлогыг зөв шийдэх түлхүүр гэж үзэж байна.

Одоогийн үйлчилж буй хуулиар хувийн орлогын дийлэнх нэр төрөлд нэгдсэн нэг хувь хэмжээ, цөөхөн орлогын төрөлд тусгайлсан хувь хэмжээг хэрэглэж байгаа нь тэгш хувьтай татвар (flat tax) ба хосолсон орлогын (dual income tax) татварын шинж чанарыг агуулсан холимог (semi dual-semi flat) системийн арга нэвтрүүлж байна гэж үзэж болохоор байна.

Цаашид энэхүү татварын суурийг бодитой тооцохын тулд дараах үзүүлэлтүүдийг харгалзан үзэх шаардлагатай гэж дүгнэж байна. Үүнд: Хөдөлмөр эрхлэлтийн орлого буюу цалин түүнтэй адилтгах орлогод татвар ногдуулахдаа зөвхөн ЭМД болон НДШ-ийг хасахаас гадна тэжээлэгчийн тоо, татварын суурь хөнгөлөлтийн хэмжээ, өрхийн хадгаламж хуримтлалын хувь зэрэг үзүүлэлтүүдийг харгалзан татвар ногдуулах орлогыг тодорхойлох;

Сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнуудад тулгамдаж буй асуудал нь

орлогын ялгаатай байдал/орлогын эрсдэлийн асуудал хэвээр байна. Манай улсын хувьд ч энэ асуудал бодит хэвээр байгаа учир орлогын ялгаатай байдлыг татварын өсөн нэмэгдэх хувь хэмжээг нэвтрүүлж бодлогоор зохицуулах боломжтой зэрэг санал дэвшүүлж байна.

Ашигласан материал

1. Сувдаа, Д. (2016). Хувь хүний орлогын албан татвар ногдуулалт. УБ хот: Тод үсэг ХХК.
2. УБСЕГ. (2015). Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа. УБ хот.
3. УБСЕГ. (2015). Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа. УБ хот.
4. УНДЕГ. (2014). Статистик мэдээ. УБ хот.
5. УНДЕГ. (2014). Статистик мэдээлэл. УБ хот.
6. УНДЕГ. (2014). Статистик мэдээлэл. УБ хот.
7. ҮСХ. (1989-2014). “Монгол улс зах зээлд” статистикийн эмхэтгэл. УБ хот.
8. ҮСХ. (2007-2008). Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа. УБ хот.
9. IMF. (2011). Revenue Mobilization in Developing Countries.
10. КРМГ. (2011). Individual Income tax and Social Security Rate Survey.
11. КРМГ. (2015). Global Tax Rate Survey.
12. Michael, K., Yitae, K., & Ricardo, V. (2006). Flat tax: Principles and Evidence. IMF Working Paper, 06/218, 6-7.
13. Simons, H. (1938). Personal Income Taxation: the Definition of Income as a Problem of Fiscal Policy. Chicago: University of Chicago Press, p.49.